

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймгийн Засаг даргад үүрэг чиглэл болгосон
2021 оны эхний хагас жилд хяналтад авсан

тогтоолын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2021.06.28

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас аймгийн Засаг даргад 2021 оны эхний хагас жилд тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон 4 тогтоолын 6 заалт, 4 хуралдааны тэмдэглэлийн 11 заалтын хэрэгжилтийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн.

Хэрэгжилтийн явцад Засгийн газрын 2020 оны 206 тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-ын дагуу хяналт шинжилгээ хийхэд 71.8 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь- 6, 70 хувь- 7, 30 хувь- 2, 0 хувь-1, ХБ-1 заалт байна.

Дээрх дүнгээс харахад Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 6 заалт нь нийт заалтын 35.2 хувь, хэрэгжих шатанд буюу 70 хувьтай 7 заалт нь нийт заалтын 41.1 хувь, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай 2 заалт нь нийт заалтын 11.7 хувь, хэрэгжээгүй буюу 0 хувьтай 1 заалт нь 5.8 хувь, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 1 заалт нь 5.8 хувийг тус тус эзэлж байна.

Хурлын тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр үүрэг чиглэл болгосон тогтоолын хүрээнд ололттой хэрэгжсэн дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:

1.Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх цахим сургалтыг 2021 оны 3 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв ТББ-тай хамтран зохион байгуулж, сургалтад хамрагдсан 161 хүн цахим шалгалтад орж 48 хувийн амжилтаар 78 хүн тэнцэж нийт сертификат эзэмшигчийн тоо 187 болсон байна.

2. “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлэн Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх зорилгоор “Зөв зөвд шударга зөв” сэдэвт соён гэгээрүүлэх аяныг аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ, сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд зохион байгуулсан. Аяны хүрээнд 15 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уриалгад аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нар нэгдэн мөн сум, байгууллагуудыг хамт олноо уриалан ажиллахыг нийт хэлтэс, агентлаг, сумдын удирдлагад уриалсны үр дүнд сум, хэлтэс, агентлагууд уриалгад нэгдэж, цахим сурталчилгаа, уриалга, самбар, булан байгуулж, төрийн албан хаагчид шударга ёс – хөгжил дэвшилд хамтдаа ажиллахаа төрөл бүрийн хэлбэрээр илэрхийлсэн. Ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчилсан гарын авлагыг олшруулан иргэдэд түгээж, аймгийн ЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны үүдэн хэсэгт “Дундговь авлигагүй хөгжинө”, “110 дугаарын сурталчилгаа”-ны зурагт баннерыг байнга байршуулан сурталчилсан ажиллаж байна.

Явцын хяналт шинжилгээгээр дараах асуудалд анхаарч, хэрэгжилтийг эрчимжүүлэх зөвлөмж өгч байна.

1. 2021 оны 5 дугаар сарын байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяаны байгууллагуудын шилэн дансны хэрэгжилт 82,2 хувьтай, нийт мэдээллэх 10001 мэдээллээс 7851 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 373 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа тул хугацаа хоцроож мэдээлж байгаа удирдлагуудын хариуцлагыг сайжруулах

2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэн хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцож хорооны хурлаар хэлэлцэж байх

3. Хамтран ажиллах санамж бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5. Түр хамгаалах байрны байршил нууц байна гэсэн заалттай нийцэхгүй байгаа учир аймгийн Засаг даргын Тамгын газрын өмчлөлийн орон сууцнаас түр хамгаалах байр хэлбэрээр ашиглуулах боломжгүй тухай аймгийн Засаг даргын 2021 оны 05-р сарын 27-ны 1/877 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. Цаашид түр хамгаалах байрны асуудлыг шийдвэрлэх

5. Тарвага нутагшуулснаас хойших хамгаалалт, хяналтын ажил явуулах санхүүгийн болон менежментийн төлөвлөлт байхгүй байгаа тул төлөвлөлтийг хийж батлуулах

6. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэн авч хэрэгжүүлж байгаа ажлын талаарх мэдээллийг тухай бүр танилцуулж ажиллах

Зөвлөмжийг холбогдох хэлтэс агентлагт хүргүүлж, жилийн эцсээр дахин биелэлтийг гаргаж ирүүлэх шаардлагатай.

Илтгэх хуудас бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн

ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг